

БАГШ БЭЛТГЭХ ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Г.Баярмаа, доктор, БоСС

Abstract: In the scope of the reformation of Mongolian education system, certain actions such as transitioning to a 12-year education system and developing and implementing national educational programmes that meet the education standards are being taken step by step. In order to successfully implement these changes, the reformation of the Mongolian school of education and improvements in management are needed. At this time, "Education Sector Reform" project has started within the framework of Asian Development Bank's "Education Development 4" programme. A part of the project's aim is to assist schools of education with finance and technologies. Therefore, we are aiming to develop the facilities needed in schools of education, support library performance, enrich the library's resources and increase the capacity of human resources and carried out a research to determine the current condition of training facilities. The results are reflected on the "article". Observation, focused conversation and questioning methods were used to carry out the research. The results tell that supply, resources and accessibility of the facilities in schools of education can't meet the demands.

Түлхүүр үг: Багш бэлтгэх сургууль, сургалтын хэрэглэгдэхүүн

Удиртгал

Бодлого, зохицуулалтын баримт бичгүүдээс үзэхэд Их, дээд сургуулийн сургалтын орчинг сайжруулах, багш болох оюутнуудын сурч боловсрох нөхцөл боломжийг бүрдүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байгаа хэдий ч их, дээд сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүний нэр төрөл, хангамж, хүртээмж хангалтгүй байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна. Тухайлбал, 2006 онд Боловсролын хүрээлэнгээс явуулсан их, дээд сургуулийн сургалтын орчны стандартын зарим үзүүлэлтийн судалгааны дүнгээс үзэхэд нийт 152 сургуулийн дөнгөж 8 хувь буюу 12 сургууль 1 компьютерт ногдох оюутны тооны үзүүлэлтийг, 52 хувь буюу 79 сургууль 1 оюутанд ногдох ном, сурах бичгийн нормыг хангасан байна¹.

Дээрх судалгааг эс тооцвол Багш бэлтгэх сургууль (ББС)-ийн багш мэргэжлийн суурь хичээлийн багш, оюутанд зориулсан сургалтын хэрэглэгдэхүүний хангамж, нөөц, хүртээмж болон багш нарын сургалтын хөтөлбөр боловсруулах ур чадвар, хэрэгцээ шаардлагын талаар хийсэн судалгаа, цуглуулсан мэдээлэл хомс байна. Аливаа сургалт, түүний дотор багш бэлтгэх сургалтын хэрэглэгдэхүүн нь боловсролын стандарт болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд хийж буй өөрчлөлт шинэчлэлд томоохон үүрэг гүйцэтгэдэг.

¹ Боловсролын хүрээлэн. (2006). Их, дээд сургуулийн сургалтын орчны стандартын зарим үзүүлэлт. Судалгааны тайлан

Сурах бичиг, үзүүлэн тараах материал, сургалтын техник хэрэгсэл, гарын авлага зэрэг нь тухайн боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн үзэл санаа, агуулгыг нэгтгэн зангидаж, биежүүлсэн хэлбэр байдгаараа онцлогтой. Өөрөөр хэлбэл, боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр хэрэгжих эсэх нь сургалтын хэрэглэгдэхүүнээс шууд хамаардаг.

Судалгааны зорилго. "Боловсролын салбарын шинэчлэл" төслийн хүрээнд багш бэлтгэх их, дээд сургуулийн сургалтад хэрэглэж буй сургалтын хэрэглэгдэхүүний өнөөгийн байдлыг тодорхойлж, ББС-ийн багш нарт зориулсан модуль сургалтын агуулга, арга зүйг боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд үүний тулд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

1. ББС-ийн номын сангийн фонд дахь багш мэргэжлийн хичээлийн хэрэглэгдэхүүний байдлын талаар мэдээлэл цуглуулах
2. Багш мэргэжлийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүний нэр төрөл, боловсруулалтын түвшин, хүртээмжийн өнөөгийн байдлыг хичээлд ажиглалт хийх замаар тодорхойлох
3. ББС-ийн багш нарт зориулсан модуль сургалтын агуулга, арга зүйг боловсруулахад шаардлагатай мэдээлэл цуглуулах

Судалгааны арга. Хичээлийн ажиглалт, фокус бүлгийн ярилцлага, асуулгын аргыг судалгаанд хэрэглэсэн.

Судалгааны хүрээ. 2010-2011 оны хичээлийн жилд

23 чиглэлээр багш бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлдэг нийт 33 их, дээд сургууль байгаагаас судалгааны түүвэрт хамруулах сургуулийг сонгохдоо дараах хүчин зүйлсийг харгалзан үзлээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын түвшин
- Багш бэлтгэж буй боловсролын чиглэл
- Өмчийн хэв шинж

Судалгааны явцад их, дээд сургуулийн 11 лекц, 11 семинар, 1 лабораторийн хичээлд ажиглалт хийсэн бөгөөд сурган хүмүүжүүлэх чиглэлээр 7, сэтгэл судлалаар 5, мэргэжлийн дидактикийн 11 хичээлийг ажиглажээ.

Судалгаанд оролцогчид. Судалгаанд МУБИС, МУИС, Ховд их сургууль, Дорнод дээд сургууль, Соёлын дээд гэсэн төрийн өмчийн 5, Гурван-Эрдэнэ, Үндэсний биеийн тамирын дээд гэсэн хувийн өмчийн хоёр сургуулийн номын санч, багш, оюутнууд оролцсон. Багш нараас авсан асуулгад нийт 59 багш оролцсоноос нийгмийн ухааны 11, хүмүүнлэгийн ухааны 14, байгалийн ухааны 5, математик, мэдээлэл зүйн 10, бага ангийн 1, бусад мэргэжлийн багш 18 байлаа. Оюутнаас авсан асуулгад нийт 159 оюутан оролцсоноос мэргэжлийн чиглэлээр нь авч үзвэл нийгмийн ухааны 16%, хүмүүнлэгийн 30%, байгалийн ухааны 26%, математик, мэдээлэл зүйн 22%, бага ангийн 6% байлаа. Ярилцлагад 75 оюутан, 56 багш, 21 номын санч оролцсон.

ББС-ийн сургалтын хэрэглэгдэхүүний нөөц, хангамж.

Бид багш бэлтгэх сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүний нөөц, хангамжийн байдлыг тодорхойлохдоо дараах эх сурвалжид тулгуурласан болно. Үүнд:

- энэ талаар баримталж буй бодлого, зохицуулалт
- судалгааны хамрагдсан сургуулиудын номын санчид, багш, оюутнуудтай хийсэн ярилцлагаар цуглуулсан мэдээлэл
- хичээл ажиглалт болон багш, оюутнаас авсан асуулга судалгаагаар цуглуулсан мэдээлэл зэрэг болно.

Үүнээс ББС-ийн багш мэргэжлийн хичээлүүдэд ашиглаж буй ном, сурах бичиг болон хэвлэмэл хэрэглэгдэхүүний нөөц, хангамжийг ярилцлагаар, ээлжит хичээлд ашиглаж буй тарааж өгөх материал, Power Point программаар хийсэн танилцуулга, бодит үзүүлэн зэрэг хэрэглэгдэхүүнийг хичээл ажиглалт, асуулгаар цуглуулсан мэдээллийг тус тус үндэслэн тодорхойлолтыг оролдсон болно. Энэхүү судалгаагаар их, дээд сургуулийн номын сангийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой тодорхой шийдэл хийхийг зохиогүй

болно.

Багш бэлтгэх сургуулийн сургалтын хэрэглэхүүний нөөц, хангамжийн байдлын талаарх судалгааны мэдээлэл, баримтаас дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Багш мэргэжлийн багц хичээлийн ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн туйлын ховор ялангуяа, мэргэжлийн дидактикийн сургалтын хэрэглэгдэхүүнээр зайлшгүй хангах асуудал анхаарал татахуйц хэмжээнд хүрсэн байна. Багш бэлтгэх сургуулийн мэргэжлийн дидактик болон сурган хүмүүжүүлэх дадлагад ашиглах зорилгоор юуны өмнө ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг худалдан авах шаардлагатай байна.
2. Сургалтад ашиглаж буй ном, сурах бичгийн тухайд номын фондод буй тоо ширхэг хүртээмжгүй, сонголт хийх боломжгүй, цөөн тоотой болон зөвхөн ганц нэг зохиогчдын номыг л оюутнууд ашиглаж байна.
3. Багш мэргэжлийн багц хичээлийн ном, сурах бичгийн олдоц хүртээмж хангалтгүй, шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа нь энэ чиглэлийн ном, сурах бичгийн зах зээл дэх нийлүүлэлт бага, цөөн байгаатай мөн холбоотой гэж үзэх боломжтой байна. Тухайлбал, 2005 онд багш мэргэжлийн багц хичээлийн сургалтын хөтөлбөр шинэчлэгдсэнээс хойш тухайн хичээлийг зааж буй багш нарын ганц нэгээрээ гаргасан гарын авлагын шинжтэй сургалтын хэрэглэгдэхүүнээс өөр дорвитой, үндсэн сурах бичиг болохоор бүтээл гаргаагүй байна.
4. Багш бэлтгэх сургуулиудын хувьд номын фонд бүрдүүлэлтийн механизм тодорхой, дүрэм журмаар хангалттай зохицуулагдсан гэж үзэх боломжгүй байна. ББС-иуд “тэнхимээр хэлэлцүүлсэн байх, ...профессорын саналыг авсан байх” гэх мэт шаардлагаар зохицуулахыг оролдож байгаа нь тэр бүр багш, суралцагчдын эрэлт, хэрэгцээг хангахгүй байна гэж үзэх үндэстэй байна.
5. МТХ-ийг ашигласан сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, сургалтын бодит үзүүлэн хэрэглэгдэхүүнээр ББС-ийг хангах хэрэгцээ өндөр байна. Үүнтэй холбоотойгоор ББС-ийн сургалтын техник хэрэгслийн хангамж, хүртээмжийг талаар улсаас болон тухайн сургуулийн зүгээс тусгайлсан дэмжих бодлого явуулах шаардлагатай нь харагдаж байна.
6. МУ-ын Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хууль, Боловсролын салбарын Мастер төлөвлөгөө, “Боловсрол” хөтөлбөр зэрэг зохицуулалтын болон бодлогын баримт бичигт сургалтын хэрэглэгдэхүүнтэй

холбоотой зүйл заалт цөөнгүй боловч ерөнхий, хэрэгжүүлэх механизм тодорхойгүй байна. Энэ нь их дээд сургуулийн түвшинд ч мөн адил байна. Тухайлбал, үндэсний болон тухайн ББС-ийн түвшинд ном, сурах бичигт болон номын фондод худалдан авах, хэвлэхэд тавих нийтлэг шаардлага, стандарт байхгүй байна. Номын сангийн фондод худалдан авах ном, сурах бичигт тавих шаардлага, стандарт алга байгаагаар холбоотойгоор фонд баяжуулалтын бодлого алдагдсан байж болох талтай.

ББС-ийн сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага

ББС-ийн сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, сургалтын модулийн агуулга, арга зүйг боловсруулахын тулд фокус бүлгийн ярилцлагаар сурах бичиг, гарын авлагын агуулга нь оюутан суралцагчдын хэрэгцээг хангаж буй байдал; хичээлийн ажиглалтаар сургалтын хэрэглэгдэхүүний боловсруулалтын түвшин; асуулгаар сургалтын хэрэглэгдэхүүний нэр төрөл, түүнийг ашиглах нөхцөл боломж, багш нарын сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, боловсруулах туршлага, тэдгээрийг бэлтгэхэд тулгардаг бэрхшээл, тэдэнд үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох боломжтой байлаа.

Судалгааны дүнгээс сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагын талаар дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Их, дээд сургуулийн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих жишиг шаардлага (стандарт)-гүй байгаа нь сургалтын хэрэглэгдэхүүний чанарт сөргөөр нөлөөлж байна.
- Одоогийн байдлаар хэрэглэж буй сурах бичиг, гарын авлагын агуулга нь тэр бүр оюутны хэрэгцээг шаардлагад нийцэхгүй, ерөнхий боловсролын шинэчлэлийн хүрээнд хийж буй агуулга, арга зүйн шинэчлэлтэй нийцэхгүй байгааг оюутнууд тэмдэглэж байна.
- Сургалтын техник хэрэгслийн хангалтгүй байдлаас багш нар өөрсдийн бэлтгэсэн үзүүлэн, танилцуулгыг ор нэрийн төдий харуулах үзүүлэх байдалтай сургалт явуулж байна. Их, дээд сургуулийн лекцийн заал, түүний техник хэрэгсэл шаардлага хангахгүй байгаагийн дээр багш нарын бэлтгэсэн танилцуулга нь харагдахуйц байх, ойлгомжтой байх зэрэг үзүүлэнд тавигдах наад захын шаардлагыг хангахгүй байна.
- Багш нарын орчин үеийн МХТ болон техник

хэрэгслийг ашиглах чадвар хангалтгүй байна.

- Тухайн ээлжит хичээл дээр багш нар үзүүлэн (Power Point presentation), тараах материал бэлтгэн ашиглаж байгаа боловч тэр нь харагдац муутай, хүрэлцэхгүй байх нь элбэг байна. Энэ нь багш нарын сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх ур чадвартай холбоотой байна.
- Өөрсдийн боловсруулсан сурах бичиг, гарын авлага бусад сургалтын хэрэглэгдэхүүнийг турших, үнэлэх, дахин сайжруулах талаар хангалтгүй ажиллаж байна.

ББС-ийн сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах, боловсронгуй болгох зарим арга зам

Номын фондын баяжилтын асуудал зарим талаар бизнесийн болон үзэл санааны ашиг сонирхол хөнддөг тул сонирхлын зөрчлийг бий болгодог. Энэхүү ашиг сонирхлын зөрчлийг шийдэх гол хүчин зүйл нь оюутан суралцагчдын болон нийгмийн ашиг сонирхол юм. Өөрөөр хэлбэл, багш бэлтгэх сургуулийн номын фондыг баяжуулахдаа сайн багш болох суралцагчдын, сайн багштай байх сургуулийн хэрэгцээг харгалзах хэрэгтэй. Үүнийг үндэс болгон багш бэлтгэх сургуулийн номын сангийн фондын баяжилтыг хийхэд баримтлах шаардлага, шалгуурыг үндэсний хэмжээнд жишиг болгосон байдлаар, тухайн сургуулийн түвшинд нарийвчилсан байдлаар дүрэм, журмаар зохицуулах боломжтой юм.

Судалгаагаар үзэхэд багш бэлтгэх их, дээд сургуулийн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих жишиг шаардлагыг (стандарт) боловсруулах, мөрдүүлэх шаардлагатай байгаа нь мөн харагдсан бөгөөд үүнийг дээрх маягаар үндэсний болон тухайн сургуулийн түвшний дүрэм, журмаар зохицуулах, одоо байгаа зохицуулалтыг боловсронгуй, тодорхой болгох замаар шийдэж болно. Судалгааны явцад багш, оюутнуудаас сургуулийн номын санд ном, сурах бичиг худалдан авах болон сурах бичиг, гарын авлагын агуулга боловсруулалтад тавих шаардлагын талаар хэлж байсан саналыг танилцуулж байна. Үүнд:

- Багш мэргэжлийн багц хичээлийн сургалтын хөтөлбөр, агуулгад нийцсэн байх
- Сургалтад тогтвортой ашиглах боломжтой байх (суурь бүтээл байх)
- Холбогдох стандартын шаардлагыг хангасан байх (багш боловсролын стандарт, хэвлэмэл номын стандарт гэх мэт)
- Багш, оюутан зэрэг сонирхлын бүлгийн

- саналыг авсан байх
- Сүүлийн үеийн байх (наад зах 1990-ээд оноос хойш)
- Хамтарсан зохиогчтой байх гэх мэт.

Их дээд сургуулийн сурах бичиг, ном гарын авлага боловсруулж, түүгээр номын санг хангаж байсан тогтолцоо алдагдаж шинэ тогтолцоо бүрэлдэж амжаагүй байгаа энэ үед жишиг шаардлагыг хангасан сурах бичиг ялангуяа, мэргэжлийн дидактикийн чиглэлээр үндэсний хэмжээний жишиг сурах бичигтэй болоход эхний удаад зохион байгуулалтын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай гэсэн багш нарын саналыг хүлээж авч “Боловсролын салбарын шинэчлэл” төслийн хүрээнд тодорхой дэмжих үйл ажиллагаа явуулж, хэрэгжүүлэх боломж байна. Үүнд:

- ББС-ийн төлөөлөлтэй тухайн мэргэжлийн дидактикийн чиглэлийн эрдэмтэн, докторуудын бүрэлдэхүүний баг байгуулах,
- Багийн гишүүдийг чадавхижуулах, багийн ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэг зэрэг тодорхой менежменттэйгээр ББС-ийн тухайн мэргэжлийн дидактикийн сурах бичгийг бичүүлэх, номын сангуудад болон номын худалдаанд түгээх боломжтой.

Энэ үйл ажиллагаа нь их, дээд сургуулийн сурах бичиг боловсруулах шинэ тутам практикийг бий болгох ач холбогдолтой. Өнөөдөр манай их дээд сургуулиудад ийм практик эхлэхийн төдий байгаа бөгөөд МУБИС-ийн ГХСС энэ талаар багагүй зүйл хийж эхэлж байгаа.

Тодруулга: Уг төслийн 2 дахь жилийн зөвлөмжийг 2008 онд МУБИС-д 15, МУБИС-д 42, Хүмүүнлэгийн Их Сургуульд 2, Ховд, Дорнод, Архангай, Баян-Өлгий аймаг дахь багш бэлтгэх сургуульд тус бүр 5 ширхгийг олгосон бол 3 дахь жилийн зөвлөмжийг 2009 онд МУИС-д 15, МУБИС-д 42, Гурван-Эрдэнэ багшийн дээд сургуульд 5, Хүмүүнлэгийн Их сургуульд 2 ширхгийг олгосон байна. Төслийн ажилтнаас өгсөн мэдээлэл

Сүүлийн жилүүдэд боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухаан, мэргэжлийн дидактикийн ном, сурах бичгийг орчуулах, сургалтад ашиглах явдал зогсонги байдалд орсон байгааг анхааралдаа авч сонирхлын талууд хамтран үйл ажиллагаа явуулах хэрэгтэй байна. Төслийн хүрээнд орчуулах боломжтой ном, сурах бичгийн судалгаа, жагсаалтыг гаргаж, орчуулгын үйл ажиллагааг дэмжиж болох юм.

Сургалтын техник хэрэгслийг сургалтын хэрэглэгдэхүүний нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулалтын болон санхүүгийн хувьд дэмжих нь

төслийн хүрээний нэг хийх ажил юм. Үүний тулд тооцоо, статистикийг нарийвчлан гаргаж, энэ чиглэлээр мөрдөж буй стандартын хэрэгжилтэд үзлэг хийсний үндсэн дээр бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжтой. Үүний зэрэгцээ багш нарын МХТ-тэй ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх агуулгыг төслийн хүрээнд зохион байгуулах сургалтын модулийн агуулгад оруулах хэрэгтэй.

Судалгааны хүрээнд шийдэхийг зориогүй боловч анхаарал хандуулах нэг асуудал бол оюутныг тухайн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гарын авлага, тараах материалаар хангах асуудал байлаа. Бидний жишиг болгон авдаг бусад улс орны их дээд сургуулийн туршлагаас үзэхэд хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөр бүрээр наад захын мэдээлэл, сургалтын үед ашиглах тохиолдол, жишээг агуулсан гарын авлагыг тухайн хичээл орох үед оюутан нэг бүрт тарааж өгдөг. Уг хэрэглэгдэхүүний санхүүжилт нь сургалтын төлбөрт шингэсэн байх, ном гарын авлагын мөнгийг тусад нь төлөх гэсэн хоёр арга замаар шийдэгддэг. Үүнийг бид судалж хэрэгжүүлэх цаг нэгэнт болсон байна.

Багш бэлтгэх, давтан бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын салбарын үйл явцтай нягт холбоотой юм. Энэ ч үүднээс манай улсын ерөнхий боловсролын тогтолцооны хүрээнд хийж буй шинэчлэл нь багш бэлтгэх тогтолцооны шинэчлэлтэй хамт хийгдэх учиртай. Өөрөөр хэлбэл, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичигт хийж буй шинэчлэл нь ББС-ийн оюутны ширээнд шууд бууж байхад нь ирээдүйн багш нарт туйлын чухал байна. Мөн ерөнхий боловсрол олгож буй сургалтын арга зүйн шинэчлэл, дидактик шийдэл хийх арга зүйтэй холбоотой үндэсний хэмжээний төсөл хөтөлбөрийн үр дүнг хүртэх нэг үндсэн сонирхлын бүлэг нь ББС-ийн оюутнууд юм. Гэтэл энэ чиглэлээр хийж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнг нь хүртэх талаар тодорхой зохион байгуулсан ажил учир дутагдалтай байна. Тухайлбал, БСШУЯ-наас Японы Олон улсын Хамтын ажиллагааны байгууллага “ЖАЙКА”-тай хамтран 2006 оноос хэрэгжүүлсэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн хүрээнд суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйг суурь боловсролын стандартад нийцүүлэн хөгжүүлэх зорилт тавин ажилласны дүнд их, дээд сургуулийн болон ЕБС-ийн багш нарын бүрэлдэхүүнтэй багууд 24 зөвлөмж боловсруулсан байна. Эдгээр зөвлөмжийг тодорхой үе шат, туршилтын үндсэн дээр холбогдох сонирхлын бүлгүүдийн

төлөөллийн оролцоотой боловсруулсан нь ихээхэн ач холбогдолтой байна.

Байгалийн ухааны хичээлийг заах, хичээлийг судалгаа хийх арга зүйг багтаасан эдгээр зөвлөмж нь багш бэлтгэх сургуулийн мэргэжлийн дидактикийн хичээлийн сургалтын бүрэлдэхүүн болох боломжтой байна. Гэвч эдгээр нь тухайн сургуулийн номын санд хүрэлцээгүй тоогоор очсон бөгөөд багш, оюутны хэрэгцээтэй гарын авлага болох нь багш бэлтгэх сургуулийн багш нартай хийсэн ярилцлагын явцад харагдаж байсан тул дахин хэвлэх, түгээх талаар холбогдох байгууллагатай санал солилцох нь зүйтэй юм.

Одоо хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн нөөцийг ашиглан багш нарын сургалтыг хөтөлбөр боловсруулах ур чадварыг дэмжсэн сургалт зохион байгуулах, сургалтын үр дүнг сургалтад шууд хэрэглэхэд дэмжих үйл ажиллагааг сургуулийн удирдлагууд зохион байгуулах боломж байна. Тухайлбал, тус төслийн хүрээнд сургалтын хэрэглэгдэхүүн хариуцсан олон улсын зөвлөхийн зохион байгуулах “ББС-ийн багш нарыг чадавхжуулах” сургалтын модульд дараах агуулгыг багтаах нь зүйтэй. Үүнд:

- Хичээлийн зорилго, агуулгад нийцүүлэн сургалтын хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгох, агуулгыг тодорхойлох арга зүй
- Хичээлийн явцад зүй зохистой хэрэглэх; оюутныг сургах арга барилд сургах, хөгжүүлэх зорилго бүхий сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах арга зүй
- МТХ-ийг ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй
- Сургалтын хэрэглэгдэхүүнээ турших, дахин сайжруулах; үнэлэх арга зүй зэрэг болно.

ДҮГНЭЛТ

“Боловсролын салбарын шинэчлэл” төслийн хүрээнд Монгол улсын ББС-ийн тодорхой төлөөллийг хангаж, тэдгээр сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж, боловсруулалт, ашиглалтын талаар энэхүү судалгааг явууллаа.

Судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд сургалтын хэрэглэгдэхүүний нөөц, хангамж, хүртээмж нь өнөөгийн багш мэргэжилтэн бэлтгэх шаардлагыг хангаж чадахгүй байна. Энэхүү судалгаанд үндэсний хэмжээнд багш бэлтгэж буй их сургууль, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй сургууль, хувийн өмчийн сургуулийн төлөөлөл хамрагдсан тул энэ дүгнэлтийг бид үндэсний хэмжээнд тархаан авч үзэх боломжтой байна.

Сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах,

боловсронгуй болгохын тулд ном, сурах бичгийн хангамжийн тогтолцоог номын сангийн үйл ажиллагаатай хамтад нь цогцоор нь шийдэх, их, дээд сургуулийн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих жишиг шаардлага (стандарт)-ыг боловсруулах мөрдөх, сургалтын техник хэрэгслийг сургалтын хэрэглэхүүний нэг хэсэг гэж үзэж хангалт ба техник хэрэгсэлтэй ажиллах багшийн ур чадварыг хөгжүүлэх зэрэг үйл ажиллагааг дээд боловсролыг салбарын болон сургуулийн түвшинд явуулах нь зүйтэй байна.

Энэхүү судалгаагаар ББС-ийн сургалтын хэрэглэгдэхүүний асуудлыг “Боловсролын салбарын шинэчлэл” төслийн хүрээнд сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, номын сангийн фондыг баяжуулах болон хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр хийж болох үйл ажиллагааг тодорхойллоо.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Боловсролын хүрээлэн. (2006). *Их, дээд сургуулийн сургалтын орчинд хийсэн судалгааны тайлан*. Улаанбаатар

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам. (2003). *Их сургууль, дээд сургууль, коллеж багшийн албан тушаалын тодорхойлолт*. Улаанбаатар

Монгол Улсын Засгийн Газар. (2008). *Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр*. Улаанбаатар

Монгол улсын их хурал. (2002). Монгол улсын боловсролын тухай хууль. Улаанбаатар

Монгол улсын их хурал. (2002). Монгол улсын Дээд боловсролын тухай хууль. Улаанбаатар

Стандартчилал, хэмжил зүйн газар. (2009) Монгол улсын стандарт Дээд боловсрол. Мэргэжлийн чиглэл: Ерөнхий боловсролын сургуулийн багш., MNS 5323-95:200968. Албан хэвлэл. Улаанбаатар

Боловсрол судлал. № 8/2012